



МОНГОЛ ДААТГАЛ

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 21/09

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай*

Монгол улсын Компанийн хуулийн 60.1., 62.1.1. болон 62.1.7. дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2. дахь заалт, ТУЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн №01 тоот тогтоолын Хавсралт №02 “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журамд тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн 15.00 цагт цахимаар хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
  - 2.1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
  - 2.2. 2021 оны ТУЗ-ийн зардлын төсвийг батлах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 04 дугаар сарын 12-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн бирж-д хүргүүлэх өдрийг 2021 оны 03 дугаар сарын 24 –ний өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2021 оны 03 дугаар сарын 26, 2021 оны 04 дугаар сарын 12-ны өдрүүд байхаар тогтоосугай.
5. Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг үнэт цаасны компанид хүргүүлэх, 2021 оны 03 дугаар сарын 26 болон 04 дүгээр сарын 12-ны өдрүүдэд өдөр тутам гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр мэдээллэх зэргээр хурлын мэдэгдэл, зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Дараах бичиг баримтыг хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг үнэт цаасны компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.
  - 6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн хуулбар;



Буухиа даатгал: +976 7010-1990  
Даатгалын лавлах: +976 1800-1990




www.mongoldaatgal.mn  
insurance@mongoldaatgal.mn



- 6.2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлзан, тэдгээрийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлт;
- 6.3. Хурлын санал хураах хуудас;
- 6.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийн төсөл;
- 6.5. Хурлын зар.
7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №01-ээр, хурлын дэгийг Хавсралт №02, танилцах бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №03-аар тус тус баталсугай.
8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 15:00 цагаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалахыг ТУЗ-ийн гишүүн О.Эрдэнэбулганд даалгасугай.
10. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:  
Дарга: Ч.Бат-Өлзий  
Гишүүд: Д.Дэлгэрмаа
11. Хурал зохион байгуулах комиссын даргаар А.Санчирмааг томилсугай.
12. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хууль тогтоомжинд нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс А.Санчирмаад даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



ГРОМОВ С.Б.